



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Боловсролын чанарын шинэчлэл төслийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2023/58/НА-СТА-ТХН

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Улаанбаатар хот 2023 он</p>	<p>Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор : Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Д.Энхдалай Утас: 260512 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn</p> <p>Аудитор: М.Ганбаатар Утас: 261628 Цахим хаяг: ganbaatarm@audit.gov.mn</p> <p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Ди Эй Би Жи Аудит ХХК-ийн захирал Н.Дэлгэрмаа Утас: 976-91910954 Цахим хаяг: dabq.audit@gmail.com</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2023.03.01 № 07/452

танай _____-ны № _____-т

Хязгаарлалтай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Боловсролын чанарын шинэчлэл төслийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Боловсролын чанарын шинэчлэл төслийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон 61,293.1 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс өндөр бөгөөд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 " өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах" заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Боловсролын чанарын шинэчлэл төслийн тайлант оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд нийт 41 үйл ажиллагаа хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 93.0 хувийн гүйцэтгэлтэй байна. Тайлант онд хэрэгжээгүй 3 үйл ажиллагааг 2023 оны төлөвлөгөөнд тусгасан. Боловсрол, шинжлэх ухааны яам, Дэлхийн банк харилцан зөвшилцөж, 2022 оны 11 дүгээр сарын 14-ний шийдвэрээр төслийн хэрэгжих хугацааг 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдөр хүртэл сунгасан байна.

Байгууллагын удирдлага нь тайлант онд санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна.

Аудитын гол асуудал

Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрийн 5 дугаар шат 2021 онд хэрэгжиж, зарцуулалтыг 2022 онд тайлагнасан. Дээрх хөтөлбөрийн хэрэгжилтэд Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/132 дугаар тушаалын дагуу нийт 21 аймаг, нийслэлийн Боловсролын газар, Улаанбаатар хотын 9 дүүргийн Боловсролын хэлтсээс хамрагдсан сургуулиудын 50 хүртэлх хувийн төслийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийгдсэн. Хэрэгжүүлэгч яамны хяналт шинжилгээ үнэлгээ гүйцэтгүүлэх зөвлөх үйлчилгээний худалдан авалтыг Дэлхийн банктай зөвшилцөн зөвлөх компаниар 2023 онд гүйцэтгүүлэх шийдвэр гарган хойшлуулсан байна.

Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал”-д Санхүүгийн тайлагнал, нягтлан бодох бүртгэл, бүртгэлийн суурь, бодлогын өөрчлөлт ороогүй байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь тайлант онд 1 зорилтын хүрээнд 2 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 99.7 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц.НАРАНЧИМЭГ



Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	6,669,303,242.45	3,562,553,460.77
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	2,272,404,818.21	3,560,153,460.77
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	2,272,404,818.21	3,560,153,460.77
3121	Төгрөг	975,134,711.79	46,445,139.89
31210	Төрийн сангийн харилцах	975,134,711.79	46,445,139.89
3122	Гадаад валют	1,297,270,106.42	3,513,708,320.88
31221	Төрийн сангийн харилцах	1,297,270,106.42	3,513,708,320.88
34	УРЬДЧИЛГАА	4,396,427,767.00	2,400,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	4,396,427,767.00	2,400,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	470,657.24	-
35420	Хангамжийн материал	470,657.24	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	35,440,543.63	24,394,030.13
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	35,440,543.63	24,394,030.13
392	Биет хөрөнгө	34,367,210.09	24,394,030.13
39203	Авто-тээврийн хэрэгсэл	80,200,000.00	80,200,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(50,124,999.75)	(58,144,999.71)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	40,400,739.00	40,400,739.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(38,910,883.56)	(40,110,863.52)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	7,532,000.00	7,532,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(4,729,645.60)	(5,482,845.64)
393	Биет бус хөрөнгө	1,073,333.54	-
39301	Програм хангамж	7,800,000.00	7,800,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(6,726,666.46)	(7,800,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	6,704,743,786.08	3,586,947,490.90
4	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,704,743,786.08	3,586,947,490.90
51	Засгийн газрын хувь оролцоо		
512	Хуримтлагдсан үр дүн	6,704,743,786.08	3,586,947,490.90
51210	Өмнөх үеийн үр дүн	6,944,586,201.98	6,704,743,786.08
51220	Тайлант үеийн үр дүн	(239,842,415.90)	(3,117,796,295.18)
5	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,704,743,786.08	3,586,947,490.90

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан
 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	5,128,482,000.00	7,608,680,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГ	5,128,482,000.00	7,608,680,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	5,128,482,000.00	7,608,680,000.00
120002	Бусад орлого	-	385,000.00
120044	Гадаад эх үүсвэрээс санхүүжих	5,128,482,000.00	7,608,295,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	5,367,606,514.04	11,237,864,487.14
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,180,428,155.32	10,351,129,587.14
210	Бараа, ажил үйлчилгээний зардал	3,180,428,155.32	10,351,129,587.14
210101	Үндсэн цалин	163,920,000.00	163,920,000.00
210201	Нийгмийн даатгалын шимтгэл	21,309,600.00	20,490,000.00
210304	Байрны түрээсийн зардал	28,800,000.00	28,615,70.00
210401	Бичиг хэргийн зардал	1,810,727.32	1,556,570.93
210402	Тээвэр, шатахууны зардал	1,929,342.76	1,670,657.24
210403	Шуудан холбооны зардал	1,974,070.80	1,968,563.90
210404	Ном хэвлэлийн зардал	1,000,000.00	942,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, ариутгал	70,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	222,428.00	300,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	1,000,000.00	814,000.00
210702	Дотоод албан томилолт	6,925,200.00	4,730,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал	2,931,568,996.25	10,111,695,386.07
210808	Банкны үйлчилгээний хураамж	-	184,339.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,579,046.00	3,194,555.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	13,318,744.19	11,046,513.50
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,187,178,358.72	886,734,900.00
223001	Бусад хөрөнгө	2,187,178,358.72	886,734,900.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	(239,124,514.04)	(3,629,184,487.14)
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО	(717,901.86)	511,388,191.96
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	546,391.43	511,388,191.96
225001	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	1,264,293.29	-
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	-	-
225004	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	-
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	(239,842,415.90)	(3,117,796,295.18)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан
 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	5,128,482,000.00	7,608,680,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,128,482,000.00	7,608,680,000.00
120	Төсөвт байгууллагын өөрийн орлого	5,128,482,000.00	7,608,680,000.00
120002	Бусад орлого	-	385,000.00
120044	Гадаад эх үүсвэрээс санхүүжих	5,128,482,000.00	7,608,295,000.00
2	УРСГАЛ ЗАРДАЛ	7,566,027,325.37	5,945,584,649.40
21	Бараа, ажил үйлчилгээний зардал	7,566,027,325.37	5,945,584,649.40
210101	Үндсэн цалин	168,339,490.00	163,920,000.00
210201	Нийгмийн даатгалын шимтгэл	21,309,600.00	20,490,000.00
210304	Байрны түрээсийн зардал	28,800,000.00	28,615,701.00
210401	Бичиг хэргийн зардал	1,810,727.32	1,556,570.93
210402	Тээвэр, шатахууны зардал	2,400,000.00	1,200,000.00
210403	Шуудан холбооны зардал	1,974,070.80	1,968,563.90
210404	Ном хэвлэлийн зардал	1,000,000.00	942,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, ариутгал	70,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	222,428.00	300,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	1,000,000.00	814,000.00
210702	Дотоод албан томилолт	6,925,200.00	4,730,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал	7,325,596,763.25	5,717,667,619.07
210808	Банкны үйлчилгээний хураамж	-	184,339.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,579,046.00	3,194,555.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(2,437,545,325.37)	1,663,095,350.60
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН	784,442,324.00	886,734,900.00
223001	Бусад хөрөнгө худалдан авса	784,442,324.00	886,734,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(784,442,324.00)	(886,734,900.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
8	Санхүүгийн мөнгөн орлогын дүн	(717,901.86)	511,388,191.96
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	(717,901.86)	511,388,191.96
9	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(717,901.86)	511,388,191.96
10	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(3,222,705,551.23)	1,287,748,642.56
11	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,495,110,369.44	2,272,404,818.21
12	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,272,404,818.21	3,560,153,460.77

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан*2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон**/төгрөгөөр/*

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	6,944,586,201.98	6,944,586,201.98
Тайлант үеийн үр дүн	-	(239,842,415.90)	(239,842,415.90)
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	6,704,743,786.08	6,704,743,786.08
Тайлант үеийн үр дүн	-	(3,117,796,295.18)	(3,117,796,295.18)
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	3,586,947,490.90	3,586,947,490.90

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан
 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭБЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,901,157,200.00	6,832,319,549.40	68,837,650.60	99.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,011,857,200.00	5,945,584,649.40	65,572,550.60	98.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,011,857,200.00	5,945,584,649.90	65,572,550.60	98.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,800,000.00	28,615,701.00	184,299.00	99.4
210303	Байрны түрээс	28,800,000.00	28,615,701.00	184,299.00	99.4
2104	Хангамж, бараа материалын зардал	7,630,900.00	5,967,934.83	1,662,965.17	78.2
210401	Бичиг хэрэг	1,630,900.00	1,556,570.93	74,329.07	95.4
210402	Тээвэр, шатахуун	2,400,000.00	1,200,000.00	1,200,000.00	50.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,000,000.00	1,968,563.90	31,436.10	98.4
210404	Ном, хэвлэл	1,000,000.00	942,800.00	57,200.00	94.3
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	600,000.00	300,000.00	300,000.00	50.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	814,000.00	186,000.00	81.4
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,000,000.00	814,000.00	186,000.00	81.4
2107	Томилолт, зочны зардал	6,925,200.00	4,730,500.00	2,194,700.00	68.3
210702	Дотоод албан томилолт	6,925,200.00	4,730,500.00	2,194,700.00	68.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,960,881,600.00	5,902,261,958.07	58,619,641.93	99.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,960,881,600.00	5,902,261,958.07	58,619,641.93	99.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,919,500.00	3,194,555.00	2,724,945.00	54.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,919,500.00	3,194,555.00	2,724,945.00	54.0
222	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	890,000,000.00	886,734,900.00	3,265,100.00	99.6
223001	Бусад хөрөнгө	890,000,000.00	886,734,900.00	3,265,100.00	99.6
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСБЭР	6,901,157,200.00	7,608,295,000.00	(707,137,800.00)	110.2
35	ТӨСӨБТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	6,901,157,200.00	7,608,295,000.00	(707,137,800.00)	110.2
350004	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	6,901,157,200.00	7,608,295,000.00	(707,137,800.00)	110.2
	Тохируулах бичилт		511,588,852.46		
3	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		2,272,404,818.21		
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		3,560,153,460.77		
6	ТӨСБИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1		100.0
610001	Төсвийн байгууллага	1	1		100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	4	4	-	100.0
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	3	3	-	100.0

Гурав. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 182,036.8 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 80,200.0 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 6,933,972.0 мянган төгрөгийн 2 зөвлөмжийг өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс:									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Toyota Rav4 маркын, 0269 УБЭ улсын дугаартай авто машин төсөл хэрэгжүүлэх нэгжийн балансад бүртгэлтэй боловч төслийн нэгжид биетээр оршин байгаагүй, БШУЯ-ны дэд сайд албан хэрэгцээнд ашигладаг тухай төслийн нэгжээс тайлбар ирүүлсэн. Авто тээврийн үндэсний төвөөс тээврийн хэрэгслийн лавлагаа авахад уг авто машин нь Боловсрол, шинжлэх ухааны яамны нэр дээр бүртгэлтэй байна.	1	80,200.0			1	80,200.0						
2	Тайлант хугацаанд худалдан авсан 1,018,368.1 мянган төгрөгийн бараа материал, ажил гүйлгээний анхан шатны баримт нь 101,836.8 мянган төгрөгийн цахим И баримтаар нотлогдохгүй байна.	1	101,836.8					1	101,836.8				
Дүн		2	182,036.8	-	-	1	80,200.0	1	101,836.8	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулбал зохих нийт 175 мэдээллээс 163 мэдээлэл хугацаанд нь байршуулж, байгууллагын батлагдсан орон тооны өөрчлөлт, аудитын тайлан дүгнэлт зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, батлагдсан төсөв, төсвийн хэтрэлт хэмнэлт шалтгаан тайлбарын мэдээ зэрэг 6,832,135.2 мянган төгрөгийн 10 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.	1	6,832,135.2					1	6,832,135.2
Дүн	1	6,832,135.2	-	-	-	-	1	6,832,135.2

Дөрөв. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ								
2	Төсөл, хөтөлбөр	1	1				1		
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
НИЙТ		1	1				1		